



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ

Аудитын код: ДГА-2024/03-08-НА-НА

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2024 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Э.Энхцэцэг

О.Нарангарав

Аудитор:

Э.Эрдэнэсүвд

Б.Ариунбаатар

Н.Түвшинбаатар

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
АГУУЛГА	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТ, ХАВСРАЛТЫН ТОВЬЁОГ	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	9
1.1 Аймгийн төсвийн төсөлд Сангийн яамнаас хянасан 2 төрлийн орлогыг судалгаанд үндэслэн бууруулж төлөвлөсөн байна.	9
1.1.1 Сангийн яамнаас хянасан төсөвт газрын тосны орлогыг тооцсоныг аймгийн төсвийн төслөөс хассан байна.	9
1.1.2 Орон нутгийн төсвийн орлогыг Төсвийн тухай хуульд заасан нэр, төрлөөр нь төсвийн төсөлд оруулан тооцсон байна.	10
1.2 Орон нутгийн төсвийн орлогыг 3,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	10
1.2.1 Ус, рашаан ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна	10
1.2.2 Дуудлага худалдааны орлогыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна	11
2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	13
2.1 Төсвийн төсөлд зарлагыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн 55,377.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	13
2.1.1 Орон нутгийн төсвийн төслийг 2023 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад цалин хөлс болон нэмэгдэл, урамшил, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас бусад зардлыг 3,826.5 сая төгрөгөөр бууруулан төсөвлөсөн байна.	14
2.1.2 Орон нутгийн төсвийн төсөлд хэрэгжүүлэхээр тусгагдсан ТАХ-г үнэлж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо тухайн байгууллага, сумаас ирсэн саналд үндэслэн гаргасан байна	17
2.2 Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн төсөлд тооцож тусгасан байна.	19
2.2.1 Орон нутгийн төсвийн төслийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан байна	19
2.2.2 Төсвийн төсөлд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төлөвлөсөн байна.	19
Холбогдох байгууллагын санал	21
3. ДҮГНЭЛТ	22
4. ЗӨВЛӨМЖ	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хүснэгт 1</i>	Сангийн яамны хянасан төсвийг бууруулж тооцсон орлого	9
<i>Хүснэгт 2</i>	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	10

Графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>График 1</i>	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
<i>График 2</i>	Хөрөнгө оруулалтын ТАХ-ны 2025 оны төсөв	10

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх
- Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
- Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй үр ашигтай төлөвлөсөн эсэх

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитын хамарсан хүрээ	Аудитыг орон нутгийн төсвийн 2023, 2024 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл / батлагдсан болон урьдчилсан/, 2025 оны төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг хамруулан гүйцэтгэв. Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч нь төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.
Аудитын бүрэлдэхүүн , хугацаа	Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм. Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Энхцэцэг, О.Нарангарав, аудитор Т.Мөнхтогтох, Б.Ариунбаатар, М.Дүүрэнжаргал, Н.Түвшинбаатар, Э.Эрдэнэсүвд, М.Оюу-Эрдэнэ нар гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитыг 2024 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр эхлүүлж, хуанлийн 5 хоногт гүйцэтгэсэн нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл боллоо.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "...Аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гарган хүргүүлж байна.

Уг дүгнэлтийг бэлтгэхэд Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал", Сангийн сайдын 2021 оны 204 дүгээр тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн жилийн төсөв батлах маягт", 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын холбогдох заалтыг шалгуур болгов.

Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийг Монгол Улсын Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх, төрийн албаны болон төсвийн шинэчлэлийг дэмжих бодлого, чиглэлийг үндэслэл болгон төсвийн нэгдмэл, тогтвортой, тэнцвэрт, бие даасан байдлыг бататгах, төсвийн төвлөрлийг сааруулах, өнөөдөр батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн төсөлд нийт орлогыг 133,611.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 123,383.0 сая төгрөгөөр тооцож, улсын төсөвт 10,478.0 сая төгрөгийг төвлөрүүлж, өмнөх оны үлдэгдлээс 250.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дорноговь аймаг нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг хангах, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр НҮБХХ-ийн "Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь" төслийг хэрэгжүүлэн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, орон нутгийн төсвийг үр дүнд суурилан боловсруулахад мэргэшил арга зүйн зөвлөгөө дэмжлэг авч ажилласан.

Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө Монгол Улсын Засгийн газар, Сангийн Яамнаас өгөгдсөн чиглэл, Төсвийн тухай хууль, Татварын багц хуулиуд, төсвийн орлогын гүйцэтгэлийн нэр төрлийн судалгаа тооцоо, өмнөх онуудын төсвийн орлогын хүрсэн түвшин, 2024 оны орон нутгийн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл, Сангийн яамнаас ирүүлсэн суурь орлогын хяналтын тоо зэргийг үндэс болгон аймгийн 2025 оны төсвийн суурь орлогыг 133,611.0 сая төгрөгөөр тооцсон байна. Аймгийн 2025 оны төсвийн орлогын 82.4 хувийг татварын орлогоор, 2.6 хувийг татварын бус орлогоор, 15.0 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлэхээр байна.

Аймгийн 2025 оны орон нутгийн төсөвт дараах бодлого, зарчмууд тусгагдсан байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн төвлөрлийг бууруулан, сумдын бие даасан байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийн хувьд бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх сумдын тоог нэмэгдүүлэх,
 - Улсын төсөвт төвлөрч байсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймгийн төсөвт улсын төсвөөс орлогын шилжүүлэг хэлбэрээр авах,
 - Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурласан татварын бодлого чиглэлийг хэрэгжүүлэх,

- Төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг өсгөх, зарим байгууллагуудыг шинээр байгуулах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх,
 - “Нээлттэй Дорноговь” хөтөлбөр болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагааг үргэлжлүүлэх,
 - Сүү, үдийн хоол хөтөлбөрүүдийг шинээр хэрэгжүүлэх,
 - Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх,
 - Гамшгаас хамгаалах санг бүрдүүлж хүн, малын халдварт өвчин, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах,
 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламж барих, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох зорилгоор байгаль хамгаалах сангийн зардлыг байгалийн баялаг ашигласны төлбөр, хураамжийн орлогоос журамд заагдсан хувь хэмжээгээр тооцож сумдад хуваарилах,
 - Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх гадаад зээлийн өр төлбөрийг аймгийн төсөвт тусгаж, өр төлбөрийг барагдуулах,
 - Орон нутгийн орлогын нэмэгдэл эх үүсвэрийг орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх,
 - Орон нутгийн төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах,
 - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль заасан аймаг, сумын чиг үүргийн хүрээнд орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлэх,
 - Орон нутгийн төсвийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан үр дүнд суурилан төлөвлөх зэрэг болно.

Аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх 2025 оны төсвийн төсөл, танилцуулга, аудитын явцад цуглуулсан баримт нотолгоонд үндэслэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, түүний үндэслэл, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаарх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусгав.

НЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, ногдуулалт, бүрдүүлэлт, түүнд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр төсвийн орлогыг 3,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

1.1 Аймгийн төсвийн төсөлд Сангийн яамнаас хянасан орлогыг судалгаанд үндэслэн 30,678.7 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас аймгийн 2025 оны төсвийн нийт орлогыг 102,932.3 сая төгрөгөөр хянасныг аймгийн төсвийн төсөлд 30,678.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 133,611.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.1.1 Сангийн яамнаас хянасан төсөвт газрын тосны орлогыг тооцсоныг аймгийн төсвийн төслөөс хассан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг, 4.1.29."орон нутгийн төсвийн суурь орлого" гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэр"-ийг хэлнэ гэж заасан.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах гэж хуульчилсан.

Дорноговь аймгийн 2025 оны төсвийн орлогыг СЯ-аас 102,932.3 сая төгрөгөөр хянасныг аймгийн төсвийн төсөлд 30,678.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 133,611.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүний 82.4 хувийг татварын орлого, 2.6 хувийг татварын бус орлогоор, 15.0 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Аймгийн төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас хянасан төсвийн 22 нэр төрлийн орлогоос газрын тосны орлогын 55.3 сая төгрөгийг хасан баталсан байна. /Хүснэгт №1/

Сангийн яамны хянасан төсвийг бууруулж тооцсон орлого

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Сангийн яамны хянасан	Аймгийн төсвийн төсөл	Зөрүү
Газрын тосны орлого	55.3	0	55.3
Нийт	55.3	0	55.3

Орон нутгийн суурь төсвийн хувьд Даланжаргалан, Мандах, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд, Замын-Үүд сумд бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлж, аймагт нийт 45,499.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр тооцсон байна.

1.1.2 Орон нутгийн төсвийн орлогыг Төсвийн тухай хуульд заасан нэр, төрлөөр нь төсвийн төсөлд оруулан тооцсон байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орон нутгийн төсвийг татварын болон татварын бус орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан. /Хүснэгт №2/

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

/сая төгрөг/

Орлогын төрөл	Сангийн яамны хянасан	Аймгийн төсвийн төсөл	Зөрүү
Хувь хүний орлогын албан татвар	51,790.00	51,790.00	0.00
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,600.00	-1,600.00	0.00
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	35,000.00	39,519.50	4,519.50
Хөрөнгийн албан татвар	4,829.00	5,494.00	665.00
Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,761.00	7,776.50	5,015.50
Газрын төлбөр	6,646.00	25,646.00	19,000.00
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1475	1,525.00	50.00
Татварын орлого	100,901.00	130,151.00	29,250.00
Нийтлэг татварын бус орлого	2,031.30	3,460.00	1,428.70
Татварын бус орлого	2,031.30	3,460.00	1,428.70
Татварын болон татварын бус орлого	102,932.30	133,611.00	30,678.70

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлогыг Сангийн яамнаас 8 бүлэг, 22 нэр төрлөөр хянаж ирүүлснийг аймгийн төсвийн төсөлд төсөвт байгууллагын өөрийн орлогыг нэмж, газрын тосны орлогыг хасан 22 нэр төрлөөр 30,678.7 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

1.2 Орон нутгийн төсвийн орлогыг 3,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.


Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой орлогын тооцооллыг хийхэд ус, рашаан ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогыг 3,000,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх боломжтой байна

1.2.1 Ус, рашаан ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна

Сангийн яамнаас ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 880.0 сая төгрөгөөр хянаж, аймгийн төсвийн төсөлд 48 татвар төлөгчөөс 880.0 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгасан байна.

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөлт 2020-2024 оны байдлаар авч үзвэл дараах байдалтай байна. /График №1/

ДОРНОГОВЬ АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ



Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2020-2024 онд 79.8-280.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ. Мөн төсвийн гүйцэтгэл 100.9-223.8 сая төгрөгөөр буюу 16.8-74.3 хувиар давж биелсэн байна.

Сүүлийн 4 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлээс харахад ус, рашаан ашигласны төлбөрийн хураамжийг **200.0 сая төгрөгөөр нэмж** 1,080.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөхөд боломжтой байна.

1.2.2 Дуудлага худалдааны орлогыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд дуудлага худалдааны орлогыг аймгийн ГХБХБГ-аас 9 сумын 60 байршлын 591.2 га газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулж, анхны үнээр тооцоолон 2,456.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцоолж тусгасныг, Сангийн яамнаас 1,000.0 сая төгрөгөөр хянаж, аймгийн ТАГ-т дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн төсөлд 20,000.0 сая төгрөгөөр тусгаж ирүүлсэн байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2024 онд “Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг гүйцэтгэхэд дараах байршил газруудыг дуудлага худалдаанд оруулах боломжтойг төсвийн төсөлд тусгаагүй байна.

Үүнд: Хатанбулаг суманд 2023 онд үндэслэлгүй эзэмшүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон 7 байршил газрын 515.5 сая төгрөг, 2023 онд дуудлага худалдааны төлөвлөгөөнд тусгагдаж зохион байгуулагдсан боловч амжилтгүй болсон 31 байршил газрын 1,406.5 сая төгрөгийн нийт 38 байршил 1,922.0 сая төгрөгийн суурь үнэтэй газар байна.

Мөн 2025 оны төлөвлөгөөний төсөлд дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгасан боловч орлогыг төлөвлөөгүй 3 байршлын газар 587.2 сая төгрөг газар байна.

Иймд дээрх 41 байршлын 2,509.2 сая төгрөгийн газрын дуудлага худалдааны анхны үнийг 20 хүртэл хувиар нэмж тооцоход 3,000.0 сая төгрөг орлого нэмэгдэх боломжтой байна.

ХОЁР. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Аймгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн байна.

2.1 Төсвийн төсөлд зарлагыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн 55,377.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Дорноговь аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 139,262.9 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлж, УИХ-аас баталсан МУ-ын 2025 оны Төсвийн тухай хуулиар 2025 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 68,005.8 сая төгрөгөөр буюу төсвийн саналаас 71,257.1 сая төгрөгөөр бууруулж хянасан байна.

Сангийн яамны хянасан суурь зарлага 68,005.8 сая төгрөгийн төсвийг аймгийн 2024 оны төсвийн төсөлд 55,377.3 сая төгрөгөөр нэмэн 123,383.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

2.1.1 Орон нутгийн төсвийн төслийг 2024 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад цалин хөлс болон нэмэгдэл, урамшил, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний зардлаас бусад зардлыг 2,356.1 сая төгрөгөөр бууруулан төсөвлөсөн байна.

Аймгийн төсвийн төсөлд нийт зарлагыг 123,383.0 сая төгрөгөөр тооцсон бөгөөд 65.5 хувь буюу 80,784.3 сая төгрөгийг урсгал зардалд, 34.5 хувь буюу 42,598.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны орон нутгийн суурь төсвийн төсөв хооронд шилжүүлгээр 7 суманд 3,859.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгажээ.

Төсвийн зарлагын төлөвлөлтөд Монгол Улсын Засгийн газраас төсвийн хувьд баримталж байгаа бодлого, чиглэл, шинэчлэлийн зарчмуудыг баримтлан “Дорноговь аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан хөтөлбөр, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээтэй уялдуулан үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн арга зүйг ашиглан төлөвлөжээ.

Нэгжийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний чиг үүргийн хүрээнд аймаг дахь Политехникийн коллеж, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сумын болон өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, Уламжлалт ангаах ухааны төв, Нэгдсэн эмнэлгүүд болон Биеийн тамир, спортын газар, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Номын сан, сумдын соёлын төвийн байр ашиглалттай холбоотой зардал болох гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр, бохир ус, түрээс, урсгал засварын зардалд 18,849.2 сая төгрөгийг төсөвт тусгасан байна.

Орон нутгийн урсгал зардлын суурь зарлагыг аргачлалын дагуу тооцож үзэхэд Сангийн яамны хянасан урсгал зардлын төсвийг 16,964.4 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Үүнд цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 7,236.5 сая, ажил олгогчоос төлөх НДШ зардлыг 905.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 8,035.0 сая, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 2,680.0 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 299.6 сая төгрөгөөр тус тус

нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 81.7 сая, хангамж, бараа материалын зардлыг 154.5 сая, нормативт зардлыг 7.6 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,062.6 сая. томилолт, зочны зардлыг 49.6 сая төгрөгөөр тус тус бууруулан төсөвлөсөн байна.

Энэ нь орон нутгийн 2024 оны баталсан төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл, байгууллагуудын зардлын тооцоолол, төсвийн төслийн мэдээлэлд үндэслэн зардлын тооцооллыг боловсруулжээ. Зардлыг бүлэг бүрээр авч үзвэл:

Цалин хөлс болон нэмэгдэл, урамшил:

Сангийн яамнаас цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын суурь зардлыг 21,475.2 **сая төгрөгөөр хянаж** батлан, аймгийн орон нутгийн төсөвт 7,236.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 28,711.6 **сая төгрөгөөр**, 2024 оны батлагдсан төсвөөс 1,697.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тус тус **төсөвлөсөн** байна.

Ирэх онд онд орон нутгийн төсвийн 41 байгууллагад 916 төрийн албан хаагч ажиллахаар тооцоолж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг Засгийн газраас баталсан цалингийн сүлжээгээр тооцон, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, онцгой болон нууцын, эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдлүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн тусгаснаас гадна төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах таатай боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн нэмэгдлийг бүх албан хаагчдад 60 хувиар олгох, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын төрийн албан хаагчдад сар бүр 20 хувийн орон нутгийн нэмэгдэл олгохоор тооцсон байна.

Монгол Улсын Засгийн газраас нийт төрийн албан хаагчдын цалинг 2023 оны 7 сарын 1-нээс дунджаар 40 хувиар, 2024 оны 4 сарын 1-нээс төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, төрийн захиргааны албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлсэн, ирэх 2025 онд инфляцийн түвшинтэй уялдуулан 2025 оны 1 сарын 1-нээс 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцож төсөвт тусгаснаар цалин хөлстэй холбоотой зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 32,330.7 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь нийт төсвийн 26.2 хувийг эзэлж байна.

Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 онд 792,0 мянган төгрөг болж байгаатай холбогдуулан гэрээт ажилчдын цалин хөлсний зардлыг шинэчлэн тооцсон байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

Сангийн яамнаас тогтмол зардлын **суурь зардлыг 12,217.4 сая төгрөгөөр хянаж**, аймгийн орон нутгийн төсвийн төсөлд орон нутгийн төсөвт байгууллагуудын байр ашиглалтын зардлыг **1,415.4 сая төгрөгөөр төлөвлөсөн** байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний чиг үүргийн хүрээнд Политехникийн коллеж, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сумын болон өрхийн эрүүл мэндийн төв, Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Номын сан, сумын соёлын төвийн байр ашиглалттай холбоотой зардал болох гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр, бохир ус, түрээс, урсгал засварын зардалд 18,849.2 сая төгрөгийг төсөвлөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд тусгасан

байна. Сангийн яамны хянасан суурь зардалд эдгээр байгууллагуудын тогтмол зардлын дүн орж батлагдсан байна.

Түлш халаалтын зардлын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, Чандмань-Илч ОНӨХХК, Замын-Үүдийн дулааны станц ХХК-иас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн бодит гүйцэтгэлийг тооцоолж үзэхэд төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Хангамж, бараа материалын зардал:

Сангийн яамнаас тус зардлын **суурь зардлыг 1,319.2 сая төгрөгөөр хянасныг** аймгийн төсвийн төсөлд 154.5 сая төгрөгөөр бууруулан 1,164.7 **сая төгрөгөөр төсөвлөсөн** байна.

Тус зардлын төлөвлөлт нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэж байна.

Нормативт зардал:

Тухайн зардлыг сангийн яамны хянасан 446.8 сая төгрөгийн суурь зардлаас 7.5 сая төгрөгөөр бууруулан, 439.2 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

Эмийн зардалд аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлын төсвөөс мал аж ахуйг вакцинжуулах хөтөлбөрт зориулан 389.1 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд хот тохижилтын байгууллага болон ойн ангийн албан хаагчдын нормын хувцасны зардлыг тусгажээ.

Эд хогшил, урсгал засварын зардал:

Сангийн яамнаас уг зардлын суурь зардлыг 2,735.8 сая төгрөгөөр хянаж, орон нутгийн төсвийн төсөлд 2,062.6 сая төгрөгөөр бууруулан 673.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Сангийн яамны хянасан суурь зардалд боловсролын байгууллагууд, анхан шатны эрүүл мэндийн төв, соёлын байгууллагуудын байр ашиглалтын урсгал засварын зардлыг оруулан хянасан боловч аймгийн төсвийн төсөлд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд тусгасан байна.

Аймгийн орон нутгийн байгууллагуудын урсгал засварын зардлыг 1,951.5 сая төгрөгөөр, багаж техник, хэрэгслийн зардлыг 119.0 сая, тавилгын зардлыг 2.1 сая төгрөгөөр тус тус бууруулан, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлыг 10.0 сая, төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Томилолт, зочны зардал:

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд томилолт, зочны зардалд нийт 416.3 сая төгрөгөөр буюу суурь зардлаас 49.6 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж:

Сангийн яам тус зардлыг 12,423.2 сая төгрөгөөр хянасныг төсвийн төсөлд 26,884.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 39,307.4 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

Аймгийн төсвийн төсөлд боловсролын байгууллагууд, анхан шатны эрүүл мэндийн төв, соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардал болох

тогтмол зардлууд болон урсгал засварын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд нийт 20,458.2 сая төгрөгөөр тусган төсөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн байгууллагуудын бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг бүлгийн зардлын ангилал тус бүрээр авч үзэхэд 5 зардлыг 28,6 сая төгрөгөөр бууруулан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8,035.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Бараа үйлчилгээний бусад зардал:

Сангийн яамнаас **суурь зардлыг 538.8 сая төгрөгөөр хянасныг** аймгийн төсвийн төсөлд 2,680,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, **3,219.3 сая төгрөгөөр төсөвлөсөн** байна. Тус зардлыг нэмсэн шалтгаан нь гамшгаас хамгаалах зардалд 2,000.0 сая төгрөг, байгаль орчинг хамгаалах нөхөн сэргээх зардалд 910.0 сая төгрөгийн зардал төлөвлөсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын зээл, зээлийн хүү:

Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн II үе шат төсөл”, “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурийн газруудын хөгжлийн төсөл”-ийн хүрээнд нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээний болон менежментийн чадавхыг дээшлүүлэх, цэвэрлэх байгууламж байгуулахад зориулан авсан гадаад зээлийн хүүгийн төлбөр нийт 506.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгажээ.

Урсгал шилжүүлэг:

Урсгал шилжүүлгийн зардлыг суурь зардлаас 299.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 899.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.


2.1.2. Орон нутгийн төсвийн төсөлд хэрэгжүүлэхээр тусгагдсан ТАХ-г үнэлж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо тухайн байгууллага, сумаас ирсэн саналд үндэслэн гаргасан байна

Орон нутгийн хөрөнгө оруулалт

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.2}-т “Энэ хуульд заасан шалгуурыг хангасан, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, газрын зөвшөөрөл олгогдсон ТАХ-ээг тусгана” гэж тус тус заасан байна. Мөн ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-ын 3.1.2-т “Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цахим системээр төлөвлөнө”, 3.1.3-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон байна” гэж тус тус заасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 73,267.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд санхүүжих 38,287.8 сая төгрөгийн 73 ТАХ-н тусгасан байна. Үүнд өмнөх оноос шилжсэн 24 ТАХ-нд 13,747.8 сая төгрөг, шинээр хэрэгжих 50 ТАХ-нд 24,539.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ. Харин их засварын 12 ТАХ-д 4,185.9 сая төгрөг төсөвлөжээ

Орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлыг ангилан авч үзэхэд: /График №2/



- Барилга, байгууламж барихад 24,283.2 сая төгрөг

- Хөрөнгө худалдан авахад 5,567.8 сая төгрөг

- Засвар үйлчилгээнд 6,336.2 сая төгрөг

- Үнийн нэмэгдэлд 1,687.6 сая төгрөг төсөвлөсөн байна

- Зөвлөхийн үйлчилгээ 4,523.9 сая төгрөг

- Бусад 200.0 сая төгрөг тус тус төлөвлөсөн байна

Хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгагдсан хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо байгууллага, сумдаас албан бичгээр ирүүлсэн ирсэн санал хүсэлтэд тулгуурлан гаргасан байна. Хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-нээс дараах ажлууд хууль, журмын шаардлага хангахгүй байна. Үүнд:

Орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил

- Дэлгэрэх сум Төрийн байгууллагуудын нэгдсэн автограж, зогсоол байгуулах ажил-300.0 сая төгрөг
- Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн уурын зуухны мотор солих ажил-150.0 сая төгрөг
- Сайншанд сумын суурьшлын бүсэд ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах ажил-500.0 сая төгрөг

Орон нутгийн төсвөөр хийгдэх их засварын ажил

- Алтанширээ сумын сургуулийн барилгын их засварын ажил-650.0 сая төгрөг
- Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэгийн сантехникийн их засварын ажил-190.0 сая төгрөг

Иймд нийт 1,790.0 сая төгрөгийн 5 ТАХ-г хэмжээг хасах эсвэл төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ИТХ-д оруулан батлуулах шаардлагатай байна.

Мөн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Сайншанд сумын 4 дүгээр багт дайны хонхор гэгдэх байршилд үүссэн хог хаягдлын цэгийг булшилж, хаах ажил” нь хөрөнгө оруулалтын шинжтэй бус ажил байна.

Иймээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгасан 200.0 сая төгрөгийн “Сайншанд сумын 4 дүгээр багт дайны хонхор гэгдэх байршилд үүссэн хог хаягдлын цэгийг булшилж, хаах ажил”-г хасан тус ажлыг холбогдох төсөвт төсөвлөж оруулах нь зүйтэй байна.

Замын сангийн хөрөнгө оруулалт:

Замын сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т “Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ” гэж заасан байдаг.

Замын сангийн хөрөнгөөр нийт 1,749.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, үүнээс 2025 онд 1,472.6 сая төгрөгөөр санхүүжих 2 ТАХ, зам ашигласны төлбөрийн хураамж хэвлүүлэх зардалд 5.0 сая, замын санд 7.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр зардлыг тусгасан байна.

Тус хөрөнгө оруулалтын зардалд тусгасан 7.0 сая төгрөг нь Дорноговь аймгийн засаг даргын 2018 оны А/185 захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам”-ын 3.3 /ё/-д Орон нутгийн авто зам, замын байгууламжаар тээврийн хэрэгсэл зорчсоны төлбөрийг төвлөрүүлэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу аймгийн Автотээврийн төвд төвлөрүүлэх зардлын зориулалттай гэсэн тайлбар ирүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

Сангийн яамны хянаж ирүүлсэн төсвөөр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д 55,686.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгогдохоор батлагдсан байна. Үүнээс 11,855.9 сая төгрөгийг сумын ОНХС-д хуваарилж, аймгийн ОНХС-д 44,066.0 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилан төлөвлөжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд олон нийтийн эрх ашгийг хамарсан ажлыг хийхээр төлөвлөж, иргэдийг орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж, аймгийн төв болон Замын-үүд суманд түрээсийн орон сууц төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр 24,678.2 сая төгрөгийг төлөвлөн оруулсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр 50,032.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ээс 2024 онд 21 ТАХ-нд 30,454.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор, урьд оноос шилжин ирэх 1 ТАХ-д 1,639.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төсвийн төсөлд тусгасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ТАХнээс дараах ажлууд төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Үүнд:

- Сайншанд сумын 14 дүгээр цэцэрлэгийг төвийн халаалтын шугам сүлжээнд холбох ажил 650.0 сая төгрөг

- Аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн конторын барилгын засварын ажил 91.5 сая төгрөг

Иймд нийт 741.5 сая төгрөгийн 2 ТАХ-г хэмжээг хасах эсвэл төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ИТХ-д оруулан батлуулах шаардлагатай байна.

2.2 Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн төсөлд тооцож тусгасан байна.

Аймгийн 2025 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөр, Дорноговь аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхтэй уялдсан байна.

2.2.1 Орон нутгийн төсвийн төслийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан байна

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж урамшуулал олгохыг хориглох гэж заасны дагуу ИТХ-ын төлөөлөгчдөд тэтгэмж урамшуулалтай холбоотой зардлыг төсөвлөхгүй байх талаар чиглэлийн дагуу тус зардлыг төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т “Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана” гэж заасан.

Иймд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн эрхийн хүрээнд нэмж тусгах хөрөнгө оруулалтын ажлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, төсвийн тухай хуулийн дээрх заалтад заасны дагуу санал, дүгнэлтийг авсны үндсэн тусгах талаар ИТХ-ын даргад өмнөх оны тайлангаар зөвлөмж өгсөн.

2.2.2 Төсвийн төсөлд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төлөвлөсөн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т “Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна”, 18 дугаар зүйлийн 18.6-д аймгийн ИТХ тус бодлогын баримт бичгийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ны дотор батална гэж тусгасан байна. Мөн төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь “тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх” гэж заасан.

Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө батлагдаагүй байгаа бөгөөд орон нутгийн сонгуулийн жилийн онцлогтой холбогдуулан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөртэй уялдуулан гаргах шаардлагатай тул хойшилсон байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх дараах арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ

- *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 38,287.8 сая төгрөгийн 73 төсөл арга хэмжээ*
- *Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,472.6 сая төгрөгийн 2 ТАХ*
- *Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх 44,066.0 сая төгрөгийн 19 ТАХ*
- *Их засварын 4,185.9 сая төгрөгийн 12 арга хэмжээг тусгажээ*

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-д аймгийн хөгжлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилтод хамаарахгүй ТАХ байхгүй байна.

Холбогдох байгууллагын санал:



Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

Аймгийн засаг даргын 2024 оны 11 сарын 29-ны өдрийн 01/1632 тоот албан бичгээр ирүүлсэн саналд дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

Санал 1: “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам”-ын 3.3 /ё/ дахь заалтыг үндэслэн тусгасан.

Саналд өгөх тайлбар: Дорноговь аймгийн засаг даргын 2018 оны А/185 захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам”-ын 3.3 /ё/-д Орон нутгийн авто зам, замын байгууламжаар тээврийн хэрэгсэл зорчсоны төлбөрийг төвлөрүүлэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу аймгийн Автотээврийн төвд төвлөрүүлэх зардлын зориулалттай гэж үзэн зөрчлөөс хасав.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн төсвийн төсөлд орлого, зарлагыг Сангийн яамны хянасан төсвөөс нэмж төсөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэл болон суурь судалгаанд тулгуурлан үндэслэлтэй тооцсон байна.
2. Орон нутгийн төсөвт рашаан, ус ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогыг 3,000.0 тус тус нэмж нийт орлогыг 3,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
3. Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,790.0 сая төгрөгийн 5 ТАХ, ОХНС-аар хийгдэх 741.5 сая төгрөгийн 2 ТАХ төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.
4. Аймгийн 2025 хөгжлийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн төсөл арга хэмжээ, зорилтыг бүрэн хэрэгжүүлснээр төсвийн үр ашиг дээшлэх боломжтой байна.
5. Аймгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Н.АЛДАРБАЯР ТАНАА**

1. Орон нутгийн төсвийн орлогод ус, рашаан ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогыг 3,000.0 сая төгрөгөөр нийт 3,200.0 сая төгрөгөөр нэмж тусгах.
2. Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,790.0 сая төгрөгийн 5 ТАХ, ОХНС-аар хийгдэх 741.5 сая төгрөгийн 2 ТАХ нийт 2531.5 сая төгрөгийн 7 ТАХ-г хасах эсвэл төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ИТХ-д оруулан батлуулах
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгасан 200.0 сая төгрөгийн “Сайншанд сумын 4 дүгээр багт дайны хонхор гэгдэх байршилд үүссэн хог хаягдлын цэгийг булшилж, хаах ажил”-г хасан холбогдох төсөвт төсөвлөж оруулах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

1. Орон нутгийн төсвийн орлогод ус, рашаан ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогыг 3,000.0 сая төгрөгөөр нийт 3,200.0 сая төгрөгөөр нэмж тусгах.
2. Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,790.0 сая төгрөгийн 5 ТАХ, ОХНС-аар хийгдэх 741.5 сая төгрөгийн 2 ТАХ нийт 2531.5 сая төгрөгийн 7 ТАХ-г хасах эсвэл төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд ИТХ-д оруулан батлуулах
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгасан 200.0 сая төгрөгийн “Сайншанд сумын 4 дүгээр багт дайны хонхор гэгдэх байршилд үүссэн хог хаягдлын цэгийг булшилж, хаах ажил”-г хасан холбогдох төсөвт төсөвлөж оруулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 12 сарын 10-ны дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 0141

Сайншанд сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", 2022 оны А/67 тушаалаар баталсан "Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал, 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн "Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт өгөх"-аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

0120003867

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:




Т.ГАН-ӨЛЗИЙ

У.ОЮУНТҮЛХҮҮР

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

АХЛАХ АУДИТОР:

АУДИТОР:



Э.ЭНХЦЭЦЭГ

О.НАРАНГАРАВ

Э.ЭРДЭНЭСУВД

Б.АРИУНБААТАР

Н.ТҮВШИНБААТАР

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

